



Э - С О Н И Н

Монголын хөрөнгийн бирж
Дугаар №17

2013 он • 7 сар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН
АРИЛЖААГААР ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗАСГИЙН
ГАЗРЫН БОНД АРИЛЖААЛЛАА



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ТОГТООЛУУД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ



“НАКО ТҮЛШ” ХК



SHARYN GOL JSC

“НАКО ТҮЛШ” ХК-ИЙН
ХУВЬЦААГ “ШАРЫН
ГОЛ” ХК САЙН ДУРЫН
ҮНДСЭН ДЭЭР
ХУДАЛДАН АВАХААР
ТЕНДЕР САНАЛ
ЗАРЛАЛАА

Үйл явдал

- МХБ-ийн арилжаагаар тэрбум төгрөгийн Засгийн Газрын бонд арилжааллаа
- Санхүүгийн зохицуулах хорооны 258, 259, 263 тоот шийдвэрүүд
- “Нако түлш” ХК-ийн хувьцааг “Шарын гол” ХК сайн дурын үндсэн дээр худалдан авахаар тендер санал зарлалаа
- Хувьцааны интернет захиалгын үйлчилгээ
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн танилцуулга хийлээ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 7 дугаар сарын арилжааны мэдээ

Сургалт

- Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалт 8 дугаар сарын 5-нд эхэлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг
Утас: 11-313747
www.mse.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД АРИЛЖААЛАГДЛАА

Монголын хөрөнгийн биржийн арилжаагаар нэг тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Засгийн газрын бонд арилжааллаа

2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 41 дүгээр тогтоолын 6 дугаарт “Хөрөнгийн зах зээлийг дэмжих бодлогын хүрээнд Засгийн газрын урт хугацаат өрийн хэрэгслийг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах

арга хэмжээг авах тухай” заасан. Энэ дагуу Монголын хөрөнгийн биржийн 2013 оны 7-р сарын 24-ний өдрийн арилжаагаар 1,010,360,000 төгрөгийн Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаа амжилттай явагдлаа.

Засгийн газрын бондын арилжааг Монголын хөрөнгийн биржээр явуулснаар

хөрөнгийн зах зээлийн үнэт цаасны хөрвөх чадвар сайжирч, санхүүгийн зах зээлд богино болон урт хугацаат өрийн хэрэгслийн жишиг үнийн болон хүүгийн түвшин тогтох боломж нээгдэх онцлогтой юм.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ДАРААХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАЖЭЭ

- ◆ “Мах” бондыг үнэт цаасны бүртгэлээс хасах,
- ◆ “Буян” ХК, “Шимтлэг” ХК-ууд тендер санал зарласныг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрчээ

2013 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 258 тоот тогтоолоор: “Буян” /MSE : BYN/ ХК-ийн нийт гаргасан 77,116 ширхэг хувьцааны 49.2 хувийг эзэмшигч нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдээс нэг бүрийг нь 200 /хоёр зуун/ төгрөгөөс доошгүй үнээр тус компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг худалдан авах,

2013 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 259 тоот тогтоолоор: “Шимтлэг” /MSE: AMT/ ХК-ийн нийт гаргасан 36,195 ширхэг хувьцааны 73.69 хувийг эзэмшигч нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдээс нэг бүрийг нь 1,000 /нэг мянган/ төгрөгөөс доошгүй үнээр тус компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг худалдан авах тендер санал гаргасныг тус тус зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоожээ.

2013 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 263 тоот тогтоолоор: жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 439,954 ширхэг “Мах” бондын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан тул Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасч, үйлдвэрлэлийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанаас чөлөөлөх тухай шийдвэрийг тус тус гаргасан байна.



“НАКО ТҮЛШ” ХК

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, 34.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 3.3 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Шарын гол” (MSE : SHG) ХК-иас “Нако түлш” (MSE : NKT) ХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан нийт хувьцааг 100 хувь буюу 12,615,721 ширхэг хувьцааг “Нако түлш” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс сайн дурын үндсэн дээр нэг бүрийг нь 209 /хоёр зуун ес/ төгрөгөөр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоожээ.



Санхүүгийн зохицуулах хорооноос “Хай би оил” ХК (MSE:HBO)-ийн нийт гаргасан 9,243,268 ширхэг хувьцааны 49.76 хувь буюу 4,595,186 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох “Firebird Global Master Holdings 2 S.A.R.L” ХХК “Firebird MF Holdings A.S.A.R.L” ХХК нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 50.24 хувь буюу 4,639,082 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 198 /нэг зуун ерэн найм/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоожээ.


ХУВЬЦААНЫ ИНТЕРНЕТ ЗАХИАЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

“Ти ди би капитал” ХХК нь үнэт цаасны интернет захиалгын үйлчилгээг нэвтрүүлээ.

“Ти ди би капитал” ХХК нь Монголын үнэт цаасны зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэхүйц цаг хугацаа, орон зайг үл хамааран дэлхийн хаанаас ч интернетийн сүлжээ ашиглан үнэт цаасны захиалга өгөх, дансаа давхар хянах зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлж буйгаараа анхдагч болж байна.

Харилцагчид интернет захиалгын үйлчилгээнд бүртгүүлснээр дараах үйлчилгээг үнэ төлбөргүй хүлээн авах боломжтой юм байна. Үүнд:

- Дансны үлдэгдэл шалгах
- Дансны хуулга үзэх
- Үнэт цаас арилжаалах захиалга өгөх
- Дансны шинжилгээ хийх
- График шинжилгээ хийх





ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

*Монголын хөрөнгийн бирж
Монголын бизнесийн зөвлөлтэй
хамтран 2013 оны 7 дугаар сарын
04-ний өдөр “Үнэт цаасны зах
зээлийн тухай хуулийн
танилцуулга” нээлттэй хурал
зохион байгууллаа.*



Монголын хөрөнгийн бирж нь Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран 2013 оны 7 дугаар сарын 04-ний өдөр 09:30-12:30 цагийн хооронд “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн танилцуулга” нээлттэй хурал, танилцуулгыг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд 90 гаруй төлөөлөгчид, үүний дотор зохицуулагч байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, хуулийн фирм, хувьцаат компаниуд, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцсон.

Тус хуралд илтгэгчид Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үндсэн зүйл, заалтууд, зах зээлд бий болж буй боломжууд болон нэвтэрч буй шинэ ухагдахуун ойлголт, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар онцлон тэмдэглэж зохицуулалт хийгээд мэргэжлийн байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны талаар танилцуулж оролцогчдын асуултад хариулт өгөв.

Хуулинд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор зах зээлд оролцогчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн зүйл заалтууд орсноос гадна мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангахтай холбоотой зохицуулалтууд мөн орсон талаар илтгэгчид тэмдэглэн хэлж байв. Түүнчлэн, үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны дараа төлбөрт системийн талаарх зохицуулалт, арилжааны дараах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Кастодианы үйл ажиллагааны зохицуулалтуудыг мөн тусгажээ. Шинэ хуулийн дагуу давхар бүртгэл, хадгаламжийн бичиг гаргах боломж нээгдэж байгаа нь дотоодын компаниуд гадаад, дотоодын зах зээл дээрээс зэрэг хөрөнгө босгох боломжийг олгож байгаа зэрэг олон ач холбогдлын талаар мэдээлэл өгсөн арга хэмжээ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх мэдээллийг дараа дараагийнхаа дугаараар дэлгэрэнгүй хүргэх болно.

САРЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2013 оны 07 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 31


Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	1 289 017
Нийт үнийн дүн /төгрөгөөр/	1 572 778 045
Хэлцлийн тоо	898
Арилжигдсан үнэт цаасны тоо	83
Зах зээлийн үнэлгээ / төгрөгөөр/	1 421 658 317 294

ТОП-20 индекс

Хаалт	14 414,23
Өмнөх хаалт	14 363,27
Өөрчлөлт /төг/	50,96
Өөрчлөлт /%/	2,47%
52 долоо хоног дээд	20 438,64
доод	13 188,46

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхгээр:					Үнийн дүнгээр:				
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн төгрөгөөр	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн төгрөгөөр
1	RMC	РЕМИКОН	539 016	95 119 761	1	MIB	МОНИНЖБАР	402 700	120 410 000
2	MIB	МОНИНЖБАР	402 700	120 410 000	2	APU	АПУ	30 537	112 990 763
3	HGN	ХӨХ ГАН	86 554	12 078 703	3	RMC	РЕМИКОН	539 016	95 119 761
4	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	48 159	5 189 114	4	TTL	ТАВАН ТОЛГОЙ	10 053	36 424 733
5	APU	АПУ	30 537	112 990 763	5	GOV	ГОВЬ	3 473	17 692 438

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт		52 долоо хоног	
					төг	%	дээд	доод
1	BTR	БАЯНТООРОЙ	970	1 437	467	48,14	1 437	1 115
2	BHR	БАЯНХАЙРХАН ХК	200	265	64,5	32,25	265	230
3	HNC	БИШРЭЛТ	2 499	3 300	801	32,05	3 300	2 870
4	BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	580	749	168,5	29,05	767	667
5	ZOO	ЗООС ГОЁЛ	1 031	1 300	269	26,09	1 430	1 030

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт		52 долоо хоног	
					төг	%	дээд	доод
1	OLL	ОЛЛОО	145	115	-29,57	-20,45	130	115
2	SUL	ГАЗАР СҮЛЖМЭЛ	33 000	27 500	-5500	-16,67	32 800	27 000
3	BAN	БАГАНУУР	4 950	4 202	-748	-15,11	4 800	4 202
4	SHV	ШИВЭЭ ОВОО	8 000	6 800	-1200	-15,00	7 700	6 800
5	UND	УНДРАГА-ӨМНӨГОВЬ	3 700	3 145	-555	-15,00	3 145	3 145